



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Атар-Өргөө" ХК-ийн 2025 оны жилийн эцсийн
санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УЛААНБААТАР ХОТ, 2026 ОН

"ИНТЕР АУДИТ" ХХК



АГУУЛГА

I. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

II. ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

III. 2025 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

IV. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ИНТЕР АУДИТ ХХК

ОГНОО 2026.04.29 1

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

1

"Атар-Өргөө" ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

ИНТЕР АУДИТ ХХК
Огноо 2025.04.29 3

ХЯЗГААРЛАЛТАЙ ДҮГНЭЛТ

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Атар-Өргөө" ХК (цаашид "Компани" гэх) ийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж буйгаар "Дүгнэлтийн үндэслэл" хэсэгт дурдсан асуудлын санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөллийг эс тооцвол "Атар-Өргөө" ХК-ийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал ба уг өдрөөр болсон жилийн орлогын дэлгэрэнгүй орлогын тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Компани нь үндсэн хөрөнгийн элэгдлийг холбогдох санхүүгийн тайлагналын стандартын шаардлагад нийцүүлэн зөв тооцоолоогүй байна. 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдөр барилга байгууламжийн бүлэг хөрөнгөд дахин үнэлгээ хийж, хөрөнгийн бодит үнэ цэн болон цаашид ашиглах нормыг шинэчлэн тогтоосон боловч 2025 оны 12 дугаар сарын 31-ээр дуусгавар болсон тайлант жилд уг шинэчлэн тогтоосон ашиглах хугацааг мөрдөөгүй, өмнөх ашиглах хугацаагаар элэгдэл тооцсон байна.

Мөн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах аргаа өөрчилж шулуун шугамын аргаас ашиглалтад суурилсан арга руу шилжсэн боловч уг аргыг сонгон хэрэглэх болсон үндэслэл, бодлогын өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу хийгээгүй. НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-д элэгдэл тооцох аргыг тухайн хөрөнгийн эдийн засгийн өгөөжийн хэрэглээний хэв шинжид нийцүүлэн сонгож, ижил нөхцөлд тууштай хэрэглэхийг шаарддаг. Дээрх зөрчлүүдийн улмаас элэгдлийн зардал 632,256 мянган төгрөгөөр дутуу тооцогдсон асуудал нь аудиторын зүгээс тус компанийн "Үндсэн хөрөнгө"-ийн дансыг хязгаарлахад хүргэв.

АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шүүн тунгаалтын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар дүгнэлт гаргахдаа авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгөөгүй. "Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл" хэсэгт тусгасан асуудлаас гадна дор дурдсан бусад асуудлыг бид тайландаа мэдээлэхүйц аудитын гол асуудал хэмээн тодорхойлоод байна.



Хувьцаа эзэмшилд орсон өөрчлөлт

2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 192/ГХ2025/01854 дугаартай Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн гүйцэтгэх хуудас-т дурдсанчлан "Бэрэн групп" ХХК нь "Атар Өргөө" ХХК-ийн 69,654 ширхэг хувьцааг барьцаанд байршуулсан байсныг гаргуулж иргэн Г.Мөнхбилэгт олгохоор шийдвэрлэсэн байна. 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн "Үнэт цаас шилжүүлэх тухай" албан бичигт "Бэрэн групп" ХХК-ийн дансанд байсан "Атар Өргөө" ХХК-ийн 69,654 ширхэг хувьцааг иргэн Г.Мөнхбилэг-ийн дансанд шилжүүлсэн байна.

Бусад авлага

2024 оны аудитын тайлангийн хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэлд "Бэрэн групп" ХХК-с авах 1,388,225 мянган төгрөгийн авлагыг компанийн удирдлага цуглуулна гэсэн хүлээлттэй байгаа боловч авлага барагдана гэдгийг нотлох хангалттай зохистой нотолгоо олдоогүй бөгөөд уг авлага нь төлөгдөх хугацаа тодорхойгүй, ямар нэг баталгаа, барьцаа байхгүй тул төлөгдөх магадлалыг тодорхойлох боломжгүй гэж дурдсан байна. Тайлант онд уг авлагаас 480,000 мянган төгрөг нь төлөгдөж, үлдсэн 908,225 мянган төгрөгийн авлагыг 16 сарын хугацаатай төлж барагдуулахаар 2025 оны 8-р сарын 15-нд "Өр төлбөр барагдуулах гэрээ" байгуулсан байна.

Хугацаа хэтэрсэн авлага

Компанийн хугацаа хэтэрсэн авлага тайлант оны эхэнд 414,089 мянган төгрөг байсан. Тухайн онд 63.06% буюу 261,132 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Тайлант онд уг авлагаас 1,023 мянган төгрөгийг цуглуулсан байна. Хугацааны эцэст 674,198 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байгаа нь нийт авлагын 31.50%-ийг эзэлж байна.

БУСАД АСУУДАЛ

Атар-Өргөө ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитыг өөр аудитор гүйцэтгэж, 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр эдгээр санхүүгийн тайлангийн талаар Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн болно.

Мөн тайлант онд Санхүүгийн зохицуулах хорооны дүгээс холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын нийцлийг үнэлэх зорилгоор газар дээрх хяналт шалгалт хийж дүгнэлт зөвлөмж өгсөн байна. (Тодруулга 25-ын тайлбарыг харна уу.)


УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу зогсолтгүй үйл ажиллагаа явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторовн тайлан гаргах нь бидний зорилго юм.



Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөртүвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд

- 1 Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай ба зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүйбайх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
 - 2 Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоодхяналтын талаар ойлголт олж авдаг.
 - 3 Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
 - 4 Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
 - 5 Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор компанийн санхүүгийн мэдээлэл эсвэл бизнесийн үйл ажиллагааны талаар хангалттай бөгөөд зохистой нотолгоо цуглуулдаг. Бид аудитын ажлын чиглэл, хяналт болон гүйцэтгэлд хариуцлага хүлээдэг төдийгүй өөрсдийн илэрхийлсэн аудитын дүгнэлтэд дангаараа хариуцлага хүлээдэг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Хүндэтгэсэн,

"ИНТЕР АУДИТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Тайлангийн огноо: 2026/04/29



ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2

"Атар-Өргөө" ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит



АУДИТ ХИЙСЭН ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	/Төгрөгөөр/	
	2024.12.31	2025.12.31
А. ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ		
1. Мөнгөн хөрөнгө	155,660,525.87	258,803,800.46
2. Авлага	2,514,417,365.32	2,142,000,620.17
3. Бараа материал	2,742,646,781.37	2,571,374,758.65
4. Урьдчилж төлсөн зардал	65,144,950.00	26,573,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,477,869,622.56	4,998,752,179.28
5. Үндсэн хөрөнгө	13,849,135,152.89	13,605,736,450.11
6. Биет бус хөрөнгө	8,135,809.94	7,949,717.91
7. Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	404,224,735.23
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,857,270,962.83	14,017,910,903.25
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,335,140,585.39	19,016,663,082.53
1. Богино хугацаат өглөг	1,235,775,221.64	1,609,653,353.08
2. Урт хугацаат өглөг	-	-
Өр төлбөрийн дүн	1,235,775,221.64	1,609,653,353.08
3. Энгийн хувьцаа	3,134,448,000.00	3,134,448,000.00
4. Халаасны хувьцаа	(45,162,000.00)	(45,162,000.00)
5. Дахин үнэлгээний нэмэгдэл	10,342,526,241.44	9,862,112,118.78
6. Хуримтлагдсан ашиг	4,667,553,122.31	4,455,611,610.67
Эзэмшигчийн өмчийн дүн	18,099,365,363.75	17,407,009,729.45
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,335,140,585.39	19,016,663,082.53
Б. ОРЛОГЫН ТАЙЛАН		
1. Борлуулалтын орлого	10,125,660,208.92	11,388,128,136.05
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	7,780,930,640.56	8,961,763,589.24
Нийт ашиг /алдагдал/	2,344,729,568.36	2,426,364,546.81
3 Хүүний орлого	886,786.48	924,792.65
4. Бусад орлого	77,342,681.93	78,663,263.55
5. Борлуулалт, маркетингийн зардал	1,616,082,071.03	1,629,710,756.18
6. Ерөнхий ба удирдлагын зардал	648,331,845.56	710,924,623.98
7. Санхүүгийн зардал	45,339,458.70	4,146,560.59
8. Бусад зардал	188,203,838.78	205,735,850.01
9. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,161,242.65)	3,011,765.97
10. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(25,102,830.48)	-
Татварын өмнөх ашиг /алдагдал/	(101,262,250.43)	(41,553,421.78)
Орлогын албан татварын зардал	-	16,863,537.43
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(101,262,250.43)	(58,416,959.21)
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ДҮН	(101,262,250.43)	(58,416,959.21)
В. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН		
1. Эхний үлдэгдэл	10,938,869,179.52	18,099,365,363.75
2. Нэмэгдсэн	7,261,758,434.66	-
3. Хорогдсон	101,262,250.43	692,355,634.3
4. Эцсийн үлдэгдэл	18,099,365,363.75	17,407,009,729.45
Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
1. Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	329,391,325.00	350,599,954.02
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(270,716,852.00)	(195,218,260.03)
3. Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(106,831,854.22)	(55,588,485.37)
4. Валютын ханшийн зөрүү	(1,161,242.65)	3,350,065.97
5. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(49,319,134.15)	103,143,274.59


ИНТЕР АУДИТ ХХК

Огноо 2026.04.29 8

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	2024.12.31	2025.12.31
/Төгрөгөөр/			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4	155,660,525.87	258,803,800.46
Дансны авлага	5	432,030,535.17	912,997,698.75
Татвар, НДШ-ийн авлага	6	34,594,201.62	144,670.74
Бусад авлага	5	2,047,792,628.53	1,228,858,250.68
Бараа материал	7	2,742,646,781.37	2,571,374,758.65
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	8	65,144,950.00	26,573,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		5,477,869,622.56	4,998,752,179.28
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	9	13,849,135,152.89	13,605,736,450.11
Биет бус хөрөнгө	10	8,135,809.94	7,949,717.91
Хайгуул үнэлгээний хөрөнгө		-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	11	-	404,224,735.23
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		13,857,270,962.83	14,017,910,903.25
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		19,335,140,585.39	19,016,663,082.53
ӨР ТӨЛБӨР			
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	12	754,554,724.79	713,136,820.16
Цалингийн өглөг	12	169,218,083.73	144,120,825.11
Татварын өр	13	69,984,841.64	439,013,238.70
НДШ-ийн өглөг	13	116,785,911.98	241,697,588.43
Богино хугацаат зээл	12	55,588,485.37	-
Хүүгийн өглөг		-	-
Ногдол ашгийн өглөг	14	50,403,850.00	50,403,850.00
Урьдчилж орсон орлого		-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	12	19,239,324.13	21,281,030.68
Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,235,775,221.64	1,609,653,353.08
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Урт хугацаат зээл		-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		1,235,775,221.64	1,609,653,353.08
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Өмч: Хувийн	15	3,134,448,000.00	3,134,448,000.00
Халаасны хувьцаа	15	(45,162,000.00)	(45,162,000.00)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16	10,342,526,241.44	9,862,112,118.78
Гадаад валютын хөрвүүлэлтийн нооц	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	17	4,667,553,122.31	4,455,611,610.67
Эзэмшигчдийн өмчийн дүн		18,099,365,363.75	17,407,009,729.45
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		19,335,140,585.39	19,016,663,082.53

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	/Төгрөгөөр/	
		2024.12.31	2025.12.31
Борлуулалтын орлого /цэвэр/	18	10,125,660,208.92	11,388,128,136.05
Борлуулалтын өртөг	19	7,780,930,640.56	8,961,763,589.24
НИЙТ АШИГ /АЛДАГДАЛ/		2,344,729,568.36	2,426,364,546.81
Түрээсийн орлого		-	-
Хүүний орлого	20	886,786.48	924,792.65
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого	20	77,342,681.93	78,663,263.55
Борлуулалт, маркетингийн зардал	21	1,616,082,071.03	1,629,710,756.18
Ерөнхий ба удирдлагын зардал	22	648,331,845.56	710,924,623.98
Санхүүгийн зардал	23	45,339,458.70	4,146,560.59
Бусад зардал	23	188,203,838.78	205,735,850.01
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /гарз/	20	(1,161,242.65)	3,011,765.97
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	(25,102,830.48)	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		-	-
Бусад ашиг /алдагдал/		-	-
Татварын өмнөх ашиг /алдагдал/		(101,262,250.43)	(41,553,421.78)
Орлогын татварын зардал	24	-	16,863,537.43
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ /АЛДАГДАЛ/		(101,262,250.43)	(58,416,959.21)
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		(101,262,250.43)	(58,416,959.21)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		(101,262,250.43)	(58,416,959.21)
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		7,261,758,434.66	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-
Бусад олз /гарз/		-	-
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН НИЙТ ДҮН		7,160,496,184.23	(58,416,959.21)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		(590)	(340)

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	ХАЛААСНЫ ХУВЬЦАА	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ)	Төгрөгөөр/ НИЙТ ДҮН
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,134,448,000.00	(45,162,000.00)	3,080,767,806.78	4,768,815,372.74	10,938,869,179.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	3,134,448,000.00	(45,162,000.00)	3,080,767,806.78	4,768,815,372.74	10,938,869,179.52
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(101,262,250.43)	(101,262,250.43)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	7,261,758,434.66	-	7,261,758,434.66
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,134,448,000.00	(45,162,000.00)	10,342,526,241.44	4,667,553,122.31	18,099,365,363.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(153,524,552.43)	(153,524,552.43)
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	3,134,448,000.00	(45,162,000.00)	10,342,526,241.44	4,514,028,569.88	17,945,840,811.32
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(58,416,959.21)	(58,416,959.21)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(480,414,122.66)	-	(480,414,122.66)
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ	3,134,448,000.00	(45,162,000.00)	9,862,112,118.78	4,455,611,610.67	17,407,009,729.45

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
Огноо 2025.04.29

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	/Төгрөгөөр/ 2025.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	11,305,882,028.01	12,405,633,319.88
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,173,723,300.09	11,836,355,252.92
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	14,171,560.08	29,665,658.39
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	117,987,167.84	539,612,408.57
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	10,976,490,702.94	12,055,033,365.86
Ажилчдад төлсөн	2,496,226,084.23	2,828,786,867.83
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	406,648,085.90	546,490,094.31
Бараа материал худалдан авахад төлсөн	6,024,483,141.38	6,354,949,595.46
Ашиглалтын зардалд төлсөн	639,551,207.48	777,157,240.27
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	151,415,615.00	170,549,962.00
Хүүний төлбөрт төлсөн	-	4,055,976.25
Татварын байгууллагад төлсөн	772,057,744.10	709,042,008.98
Даатгалын төлбөрт төлсөн	18,362,246.40	18,097,602.00
Бусад мөнгөн зарлага	467,746,578.45	645,904,018.76
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	329,391,325.07	350,599,954.02
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО		882,127.97
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүгийн орлого	-	882,127.97
Бусад мөнгөн орлого	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	270,716,852.00	196,100,388.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	270,716,852.00	196,100,388.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Бусад мөнгөн зарлага	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(270,716,852.00)	(195,218,260.03)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	106,831,854.22	55,588,485.37
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	106,831,854.22	55,588,485.37
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(106,831,854.22)	(55,588,485.37)
Валютын ханшийн зөрүү	(1,161,242.65)	3,350,065.97
БУХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(49,319,134.15)	103,143,274.59
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	204,979,660.02	155,660,525.87
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	155,660,525.87	258,803,800.46

ИНТЕР АУДИТ ХХК

Огноо 2026.04.29 (12)

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3

"Атар-Өргөө" ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ИНТЕР АУДИТ ХХК

ОГНОО 2026.04.29 13

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Атар-Өргөө" ХК (цаашид "Компани" гэх) нь 1941 оноос хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 1996 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн үүсгэн байгуулагчийн 02 тоот шийдвэрээр Хувьцаат Компани болж өөрчлөн зохион байгуулагдсан бөгөөд Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани юм. 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж 9010001008 улсын бүртгэлийн дугаар, 2039664 тоот регистрийн дугаартай гэрчилгээ авсан. Компанийн үндсэн үйл ажиллагаа нь талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа байна.

2. ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ

Мөрдөж байгаа хууль эрх зүйн болон бизнесийн орчинд компанийн цаашдын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт орох хандлага ба төсөөлөлгүй байна. Компани ирээдүйд үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулна гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1.1-д заасан стандарт (Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт)-ыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ" гэж заасан байдаг. Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/25 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлт тогтоох тухай" журмын 3.1-д шалгуурыг хангасан тул Компани нь санхүүгийн тайлан, тодруулгаа СТОУС-д нийцүүлэн бэлтгэдэг байна.

ҮНЭЛГЭЭ:

Санхүүгийн тайланд хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгийн зарчмаар хэмжиж бүртгэсэн. Зарим хөрөнгө, өр төлбөрүүдийг бодит үнэ цэнээр нь хэмждэг. Бодит үнэ цэн гэж хэмжилтийн өдөр зах зээлд оролцогчдын хоорондох ердийн ажил гүйлгээгээр хөрөнгийг шилжүүлснээр хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх дүнг хэлнэ. Бодит үнэ цэнийн хэмжилт, тодруулгын хувьд СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт-ийг мөрддөг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН ВАЛЮТ:

Байгууллагын ажил гүйлгээний хэмжих нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөг (MNT) юм. НББОУС 21 Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө-нд Санхүүгийн тайланг толилуулж буй валютын толилуулгын валют гэж заасан байдаг. Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.2 дахь "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага ажил, гүйлгээгээ үндэсний мөнгөн тэмдэгтээр бүртгэж, тайлагнана" гэж заасны дагуу Компани нь санхүүгийн тайлан, тодруулгаа төгрөгөөр бэлтгэсэн.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУУРЬ:

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн аккрузль суурьт зарчимд үндэслэн бэлтгэдэг. Ингэхдээ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузль сууриар хөтөлнө" гэж заасныг мөрдлөг болгосон.



СТОУС-ЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ:

2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон, СТОУС-ын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг өмнөх санхүүгийн жилүүдэд тууштай хэрэгжүүлсэн. Дараах өөрчлөлтүүд СТОУС-д орсон ба тайлант үе болон дараагийн тайлант үеүүдэд мөрдөгдөхөөр байна.

СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт: Бизнесийн тодорхойлолт. СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнес нь дор хаяж үйл ажиллагаа болон хөрөнгийн цогцдоо эцсийн бүтээгдэхүүнийг гаргах чадамжид их хэмжээгээр нөлөөлж чадахуйц орц болон бодит үйл явцын нэгдлийг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход шаардагдах бүх орц болон процесстэйгээр оршин тогтнох шаардлагагүй болохыг тодруулсан болно. Уг нэмэлт өөрчлөлт Компанийн санхүүгийн тайланд нөлөөгүй боловч Компани ирээдүйд аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд нөлөөлж болзошгүй юм.

НББОУС 1, НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт: Материаллаг байдлын тодорхойлолт. Нэмэлт өөрчлөлт нь "Материаллаг"-г шинэ тодорхойлолтыг: "Тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд аливаа мэдээллийг орхигдуулах, эсвэл буруу ташаа, тодорхой бус байдлаар илэрхийлэх нь байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн уг тайланг үндэслэн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлж болзошгүй тохиолдолд тухайн мэдээллийг материаллаг гэж үзнэ," гэжээ. Нэмэлт өөрчлөлтүүд нь "материаллаг"-г санхүүгийн тайлангийн агуулгаар, тухайн мэдээллийн шинж чанар ба/эсвэл хэмжээгээс хамаарна гэдгийг тодорхойлсон. Мэдээллийг буруу ташаа илэрхийлэх нь үндсэн хэрэглэгчдийн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлөхүйц бол үүнийг материаллаг гэж үзнэ. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй бөгөөд цаашид Компанид нөлөөлөхгүй гэж үзэж байна.

2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гаргасан Санхүүгийн тайлагналын суурь үзэл баримтлал: СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт: Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт 2020 оны 5 дугаар сарын 28-нд НББОУС3 нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16 Түрээс-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь түрээслэгчдэд Ковид-19 цар тахлын шууд үр дагавраас үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх СТОУС 16-ийн зааврыг хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойших жилийн тайлангийн хугацаанд хамаарна. Эрт хэрэгжүүлж эхлэхийг зөвшөөрнө.

БАТЛАГДСАН БОЛОВЧ ХЭРЭГЖИЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА СТАНДАРТУУД:

СТОУС 18 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга" стандартыг 2024 оны 4 дүгээр сард гаргасан бөгөөд 2027 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэх тайлант жилийн тайлант эхнээс мөрдөж эхэлнэ. Уг стандарт нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" стандартыг орлох бөгөөд ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан ("Орлогын дэлгэрэнгүй тайлан")-ийн толилуулгад шинэ шаардлагуудыг нэвтрүүлсэн. Үүнд ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тодорхойлсон ангиллууд болон дэд дүнгүүдийг тодорхойлох, мөн удирдлагаас тодорхойлсон гүйцэтгэлийн гол гол үзүүлэлтүүдийн талаар нэмэлт тодруулга хийх шаардлагыг багтаасан байна. Компани нь уг стандарт санхүүгийн тайланд үзүүлэх боломжит нөлөөллийг одоогоор үнэлж байна.

СТОУС 19 "Олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэггүй охин компаниуд: Тодруулга" 19 стандартыг 2024 оны 5 дугаар сард гаргасан бөгөөд 2027 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэх тайлант жилийн эхэн үеэс мөрдөж эхэлнэ. Энэхүү стандарт нь шаардлага хангасан охин компаниудад Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн шаардлагуудыг хялбаршуулсан тодруулга хийх замаар хэрэглэх боломжийг олгодог. Компани нь уг стандарт өөрт нь хамаарах эсэх болон санхүүгийн тайланд үзүүлэх боломжит нөлөөллийг одоогоор үнэлж байна.



3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

НББОУС 7 Мөнгөн Гүйлгээний Тайлан-д заасны дагуу Компанийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс болон харилцах дансанд байгаа бэлэн мөнгө, үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэл бүхий, тогтсон мөнгөн дүнд хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалтуудаас бүрдэж байна. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Тайлант үеийн эцэст гадаад валютуарх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Монгол банкнаас зарласан хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлдэг ба үүссэн ханшийн зөрүүгийн олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Компанийн мөнгө, түүнтэй адилтгах зүйлсэд дараах зүйлс хамаарагдана. Үүнд:

- ✓ Касс дахь бэлэн мөнгө. Бизнесийн өдөр тутмын ердийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор бэлнээр байршуулсан цаасан мөнгө.
- ✓ Банканд байгаа мөнгө. Бизнесийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор банкны харилцах болон хугацаагүй хадгаламжийн дансанд байршуулсан мөнгө.
- ✓ 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан
- ✓ Мөнгөтэй адилтгах зүйлс: Үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, ихээхэн өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт.

ГАДААД ВАЛЮТЫН БҮРТГЭЛ

Санхүүгийн тайланг Монгол төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт - Монгол төгрөг (MNT) юм. Гадаад улс орны валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр, гүйлгээг тайлан гаргасан өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж санхүүгийн тайланд тусгана.

Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэлд тусгана.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Анхдагч хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхдагч шууд зардлыг бодит үнэ цэнийн хэмжилт дээр нэмж тооцдог. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн анхдагч шууд зардал (гүйлгээний шимтгэл гэх мэт ажил гүйлгээний зардал)-ыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Ангилал

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө - Гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах зорилгоор эзэмшиж буй бизнесийн загвар бүхий санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд хамруулна. Гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болно. Зээл болон авлагууд нь идэвхтэй зах зээл дээрх жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд хамаарна.

Дансны авлага нь үндсэн үйл ажиллагааны явцад зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний төлөө худалдан авагч болон харилцагчаас авах мөнгөн дүн байна. Дансны авлагыг анх СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр ийн 5.1.3-д заасны дагуу СТОУС 15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого-д заасан мэдэгдэхүйц санхүүжилтийн хэлэлцээр агуулаагүй бол ажил гүйлгээ үнээр хэмжинэ.



Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах болон мөн арилжих зорилгоор эзэмшиж байгаа бол эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Мөн гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болдог санхүүгийн хөрөнгө. Түүнчлэн тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөр болон тогтсон хугацаа байхгүй дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдсэн хөрөнгө оруулалтыг энэ ангилалд багтаана.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Бодит үнэ цэнд үндэслэн гүйцэтгэлийг нь үнэлж, удирдан зохицуулдаг санхүүгийн хөрөнгийг дээр дурдсан 2 аргын шаардлага хангаагүй тохиолдолд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө гэж үзнэ. Өөрөөр хэлбэл тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн мэдээлэлд анхаарал хандуулдаг, тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг үнэлж, шийдвэр гаргахын тулд уг мэдээллийг ашигладаг, бизнесийн загварын хувьд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор ч эзэмшдэггүй, мөн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба борлуулах зорилгоор ч эзэмшдэггүй бол энэ аргын дагуу тухайн хөрөнгө оруулалтыг бүртгэнэ. Ийм санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн гүйлгээний цуглуулалт нь тухайн бизнесийн загварын зорилгыг биелүүлэхэд зөвхөн тохиолдлын шинжтэй үйл явдал байдаг. Өөрөөр хэлбэл, арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан авч, богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай санхүүгийн хөрөнгө хамаарна. Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг энэ ангилалд хамааруулж ангилахгүй.

Дараа үеийн хэмжилт

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрд үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үр ашигт хүүний түвшнээр тооцсон хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Хэрэгжээгүй зээлийн алдагдал: Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна. Зээлээр борлуулалт хийсэн үед авлагын зарим хэсэг төлөгдөх эсэх нь эргэлзээтэй болж, улмаар найдваргүй болж данснаас хасагддаг. Атар-Өргөө ХК нь найдваргүй авлагын хасагдуулгын аргыг ашигладаг.

Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр нь санхүүгийн хөрөнгийг хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар толилуулна. Үүнд:

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө – Тайлант үеийн ашиг, алдагдлын бусад орлого эсвэл бусад зардлаар

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө – үнэ цэнийн өөрчлөлтийг "бусад дэлгэрэнгүй орлого"-оор тус тус толилуулна.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгөөс олсон хүүний орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана.

Бодит үнэ цэнийн тооцоолол

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг (олон нийтэд арилжигдсан дериватив болон арилжааны үнэт цаас гэх мэт) тайлант өдрийн арилжаа дуусах үеийн зах зээлийн ханшид үндэслэнэ. Идэвхтэй зах зээл дээр нийтлэгдсэн үнийн саналууд байгаа нь бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бөгөөд хэрэв байгаа бол тэдгээрийг бодит үнэ цэнийг хэмжихэд ашигладаг. "Идэвхтэй зах зээл дээр үнэлэгдсэн" гэсэн хэллэг нь бирж, дилер, брокер, салбарын бүлэг, үнийн үйлчилгээ эсвэл зохицуулах агентлагаас санал болгож буй үнийг бэлэн бөгөөд тогтмол авах боломжтой гэсэн үг юм. Эдгээр үнэ нь зах зээлийн бодит ба тогтмол гүйлгээг илэрхийлдэг бөгөөд энэ нь хүндрэлтэй борлуулалт биш юм. Үнийг үндсэн зах зээлээс эсвэл үндсэн зах зээл байхгүй тохиолдолд хамгийн ашигтай зах зээлээс авч болно [СТОУС13(16)]. Зах зээлийн үнийг гүйлгээний зардалд тохируулах боломжгүй [СТОУС13(25)]. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо дараах түвшнийг хэрэглэнэ. Үүнд:

ИНТЕР АУДИТ ХХК

с/т/оо 2026.04.29 /19

- I түвшин – Идэвхтэй зах зээл дээрх үнэ. Тухайлбал: арилжаа солилцооны зах зээл, дилер, брокер, оролцогчдын хоорондын зах зээл.
- II түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг шууд ба шууд бусаар үзүүлэх мэдээлэл. Тухайлбал: LIBOR ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп, тодорхой банкны суурь ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп.
- III түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлэх зах зээл дээр ажиглагддаг мэдээллийг ашиглах бусад аргачлалууд

Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Үүнд:

- Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан, эсвэл
- Уг эрхээ бусдад шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийн эрсдэл өгөөж бүрэн шилжсэн эсвэл бүх эрсдэл өгөөжийг шилжүүлээгүй боловч захиран зарцуулах эрхийг нь шилжүүлсэн бол.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийг худалдан борлуулсан бол бусад дэлгэрэнгүй орлогоор өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн хэрэгжээгүй бодит үнэ цэнийн хуримтлагдсан дүнг тайлант үеийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрд хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдал (зээлийн чанар сайжирсан г.м)-тэй холбоотойгоор үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсны илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө нь хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүнээс хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацааны туршид ашиг алдагдал руу буцаахгүй.

Бодит үнэ цэнийн хэмжилтийг өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэн өсөлт эсвэл бууралт дараагийн үеүдэд өссөн эсвэл буурсан бол уг өсөлт, бууралтыг өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралтын нэгэн адил бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

Ангилал

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр - Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүл эзэмшиж гаргадаг.

Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад санхүүгийн өр төлбөр - Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү, эсвэл купон багтана. Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

БАРАА МАТЕРИАЛ

Компани нь өөрийн үндсэн үйл ажиллагаандаа болон компанийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад бараа материалын зүйлсийг ашиглана. Бараа материалын зүйлсэд хангамжийн материалыг хамааруулан авч үзнэ. Аж ахуйн үйл ажиллагаанд ашиглагдах, цаашдээ зардал болгох хангамжийн материал, шууд зарцуулагдах багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, шатах тослох материал, бусад хангамжийн шинжтэй зүйлс хамаарна. Санхүүгийн тайланд тусгагдсан бараа материал дансны эцсийн үлдэгдэл нь Компанийн эзэмшилд бодитоор байгаа бүх бараа материалын зүйлсийг багтаасан байна.

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно. Орлого ба зардлын уялдаат байх зарчмын дагуу Суурь үзэл баримтлалд заасан зардлын тодорхойлолтод нийцсэн тохиолдолд тухайн зардлыг бүртгэж бараа материалын өртөгт хүлээн зөвшөөрнө.

Бараа материалыг баланст эргэлтийн хөрөнгө хэсэгт мөнгө, авлагын дараагийн зүйл болон өртөг болон цэвэр боломжит үнэ цэний аль багаар нь тусгана. Цэвэр боломжит үнэ цэн гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүнг хэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ, УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Гадаад болон дотоодын зах зээлээс түүхий эд материал худалдан авахаар төлсөн төлбөр, бусад бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгчид төлсөн урьдчилгааг нэрлэсэн үнээр нь хэмжиж, урьдчилж төлсөн зардал, урьдчилж төлсөн тооцооны хэсэгт нэрийн данс нээж бүртгэдэг.



ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Компани нь үндсэн үйл ажиллагаанд 1-ээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглахаар хүлээгдэж буй биет хөрөнгийг үндсэн хөрөнгөд ангилж бүртгэнэ. Үүнд барилга байгууламж, авто машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, дуусаагүй барилга байгууламж, бусад хөрөнгүүд орно. Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, хүлээн зөвшөөрөх нөхцөлийн дагуу, анхны өртгөөр хэмжиж үнэлэн зохих ангиллын дансанд бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг, хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрдэнэ. Анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд тусгана.

САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

Компанийн нийт өр нь богино болон урт хугацаат өр төлбөрүүдээс бүрдэнэ. Өр төлбөрүүдийг байгууллага, хувь хүмүүст өгөх өглөг, банкны богино хугацаат зээл, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг болон бусад богино хугацаат өглөг, банкны урт хугацаат зээл гэж ангилсан.

Өр төлбөрийг нэрлэсэн үнээр бүртгэж тайлагнана. Тайлант онд компаниас төлөх өр төлбөрүүдэд хөнгөлөлт ба хасагдуулга тооцогдоогүй.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Хувь нийлүүлэгчдээс компанид анх оруулсан хөрөнгө нь энгийн хувьцаа бөгөөд нэмж оруулсан хөрөнгө байхгүй. Тайлангийн өмнөх үеийн ба тайлант оны хуримтлагдсан ашгийг тооцоологдсон дүнгээр хүлээн зөвшөөрч өөрийн хөрөнгийн бүлэгт тусган үзүүлнэ.

НОГДОЛ АШИГ

Тайлант үеийн цэвэр ашгийн хэмжээ болон хувьцааны өмчлөлийн хувийн жинд үндэслэн хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашгийг хуваарилна. Тайлант онд ноогдол ашиг зарлаагүй байна.

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Компани нь өөрийн дүрэмд заасан үйл ажиллагааны орлогыг энэ хэсэгт бүртгэдэг. Ингэхдээ СТОУС 15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого-ыг мөрддөг. Уг стандартад заасны дагуу Компани нь гэрээгээр нийлүүлэхээр амласан бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт шилжсэн үед орлогыг хүлээн зөвшөөрнө. Гэрээгээр нийлүүлэхээр амласан бүтээгдэхүүн, үйлчилгээний цаг хугацаа, шинж чанар, гэрээний бусад нөхцөлүүдээс хамааран орлогыг тодорхой хугацааны туршид хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх, эсвэл тодорхой нэг хугацаанд хүлээн зөвшөөрөх гэж ангилна.

Өмч эзэмшигчдээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий хөрөнгийн өсөлт, эсвэл өр төлбөрийн бууралт хэлбэрээр тухайн тайлант үеийн туршид бий болсон эдийн засгийн үр өгөөжийн өсөлтийг орлого гэж үзнэ. Орлого нь өөртөө үйл ажиллагааны орлого болон бусад орлогыг багтаана.

Орлогыг аливаа хөнгөлөлт, буцаалт, үнэ цэний бууралт, борлуулалттай холбоотой бусад төлбөрийг хассаны дараа хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж үнэлнэ.

ЗАРДАЛ

Үндсэн үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор гарсан үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардал, удирдлага ба борлуулалтын зардлууд, борлуулсан барааны өртөг гэх мэт өртөг зардлын зүйлс, түүнчлэн тайлангийн хугацаанд хувь нийлүүлэгчид олгосон хуваарилалттай холбогдон цэвэр өмч буурахаас бусад замаар хөрөнгийг багасгасан болон өр төлбөрийг нэмэгдүүлсэн эдийн засгийн үр өгөөжийн бууралтыг зардал гэж үзнэ. Удирдлага, борлуулалтын зардлыг орлогын тайлангийн үйл ажиллагааны зардал хэсэгт, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдал хэсэгт зардлын төрлөөр нь ангилан харуулна.

ИНТЕР АУДИТ ХХК

НОО 2026.04.29 (20)

БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Үндсэн үйл ажиллагааны орлого олохтой холбоотой шууд зардлуудыг хуримтлуулан уг дансанд бүртгэж толилуулна. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг борлуулсан барааны өртгөөс буцаасан барааны өртгийг хассан дүнгээр тооцож хуримтлуулан бүртгэнэ. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт үндсэн үйл ажиллагаатай шууд хамааралтай зардлууд, шууд хамааралтай гарсан цалин хөлс, анхны борлуулалт хийхтэй холбоотой гарсан маркетинг, технологийн зардлууд зэрэг шууд материал, шууд хөдөлмөр, өртөгт шингэх үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал тусгагдана

ОЛЗ, ГАРЗ

Олз, гарз нь үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад хөрөнгүүдийг данснаас хасах үед үүсэж болно. Эдгээрээс гадна ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөхөөр заасан хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнээс олз, гарз үүсдэг. Олз, гарзыг холбогдох стандартад заасны дагуу хэмжиж тайлагнах ба шаардлагатай тодруулгуудыг мөн санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт хийнэ.

ТАТВАР

Компани нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгддөг бүх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль гэх мэт.

ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь татварын тайлагналын зорилгоор суурь үнээс зөрүүтэй үед түр зөрүү байдлаар үүсдэг. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.



ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
4. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
Касс дахь мөнгө /төгрөгөөр/	40,277,440.00	10,412,380.76
Касс дахь мөнгө /валютаар/	2,855,932.55	3,296,875.06
Банкин дахь мөнгө /төгрөгөөр/	83,723,736.84	213,462,197.32
Банкин дахь мөнгө /валютаар/	28,803,416.78	31,632,347.32
ДҮН	155,660,525.87	258,803,800.46

Тайлбар: Компанийн мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө болон банкан дахь харилцах дансны үлдэгдлээс бүрдэнэ. Харилцах дансууд нь төгрөг болон ам.доллар, юань, еврогийн дансуудаас бүрдэж байна.

Тайлант оны эцэст гадаад валютын төгрөгтэй харьцах хаалтын ханш дараах байдалтай байна:

- Ам.доллар (USD) – 3,556.66 төгрөг
- Юань (CNY) – 508.78 төгрөг
- Евро (EUR) – 4,186.72 төгрөг

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тайлант өдрийн хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлэн санхүүгийн тайланд тусгасан.

Кассын бэлэн мөнгө нь тайлант хугацаанд компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой орлого, зарлагын гүйлгээнээс бүрдсэн бөгөөд төгрөгийн касс дахь бэлэн мөнгөний орлого-3,024,834,960 төгрөг, зарлага-3,054,834,960 төгрөг байна.

Тайлант хугацаанд кассын бэлэн мөнгөний орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. (төгрөгөөр үзүүлэв)

Үүнд:

- Бэлэн бүтээгдэхүүний түгээлтийн борлуулалтаас -2,654,848,902
- Атар-1 нэрийн дэлгүүрийн борлуулалтаас- 326,697,970
- Ажилтнууд болон бусад байгууллагаас буцаан төвлөрүүлсэн тооцооны үлдэгдэл- 886,500
- Бусад барааны борлуулалтын орлого-42,101,590

Кассын бэлэн мөнгөний зарлага нь дараах зориулалтаар гарсан болно.

Үүнд:

- Компанийн харилцах дансруу хийсэн зузаатгал-480,735,000
- Үйлдвэрлэлийн түүхий эд материал, үндсэн болон нэмэгдэл зардал, үндсэн үйл ажиллагааны борлуулалт маркетинг, удирдлагын зардалд төлсөн- 2,574,099,960 төгрөг байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
5. БОГИНО ХУГАЦААТ АВЛАГА		
Дансны авлага	432,030,535.17	912,997,698.75
Холбоотой талаас авах авлага	1,388,224,735.23	504,000,000.00
Хугацаа хэтэрсэн авлага	414,088,879.60	674,198,323.24
Ажиллагчдаас авах авлага	315,000,088.97	131,582,460.72
Бусад авлага /номин бонус карт/	13,383,177.36	13,383,177.36
Найдваргүй авлагын нөөц	(82,904,252.63)	(94,305,710.64)
ДҮН	2,479,823,163.70	2,141,855,949.43

Тайлбар: Дансны авлага нь компанийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бараа, бүтээгдэхүүний борлуулалтаас үүссэн худалдааны авлагаас бүрдэнэ. Компани дансны авлагыг төлөгдөхөөр хүлээгдэж буй хугацаанд үндэслэн хугацаандаа болон хугацаа хэтэрсэн гэж ангилж, цэвэр боломжит үнэ цэнээр хэмжин санхүүгийн тайланд тусгадаг. Компанийн зүгээс дансны авлагад үүсэх зээлийн эрсдэлийг үнэлэхдээ хасагдуулгын аргыг ашигладаг бөгөөд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг цэвэр борлуулалтаас 0,1%-аар тооцож 11,401.5 мянган төгрөгийн нөөцийг нэмж байгуулсан. Тайлант хугацаанд найдваргүйд тооцон нөөцөөс хасахаар шийдвэрлэсэн авлага байхгүй байна.

Холбоотой талаас авах авлага нь "Бэрэн групп" ХХК-д хамаарах авлага бүртгэгдсэн байна. Тайлант онд 480,000.00 мянган төгрөгийн авлага төлөгдөж үлдсэн 908,224.74 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар 2025 оны 8-р сарын 15-нд "Өр төлбөр барагдуулах гэрээ" байгуулсан бөгөөд гэрээний хавсралтад заасны дагуу авлагын богино хугацаанд цуглуулахаар хүлээгдэж буй дүнг дээрх ангилалд толилуулсан. Тайлант онд "Бэрэн групп" ХХК нь "Атар Өргөө" ХК-ийн өөрийн мэдлийн 40 хувийн хувьцаа болох 69,654 ширхэг хувьцааг иргэн Г.Мөнхбилэг-т шилжүүлсэн байна.

ИНТЕР АУДИТ ХХК

өргөө 2026. 04. 29 22

(Тодруулга 5- Богино хугацаат авлага)-ын үргэлжлэл

Хугацаа хэтэрсэн авлагад ажлаас гарсан ажилтнууд, гэрээт борлуулалтын харилцагчид, хувь хүмүүсээс авах авлага багтах бөгөөд уг авлагын үлдэгдэл тайлант онд 63.06% хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Ажиллагчдаас авах авлага нь компанийн зүгээс ажилчдад хүсэлтийн дагуу олгосон зээл болон үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцооны авлага бүртгэгдсэн байна.

Бусад авлага нь Номин сүлжээ дэлгүүртэй байгуулсан гэрээний дагуу нийлүүлсэн бүтээгдэхүүний борлуулалтаас тодорхой хувийг Номин бонус картад хуримтлуулсан дүн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
6. ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА		
ААНОАТ-ын авлага	-	144,670.74
НДШ-ийн авлага	588,177.00	-
НӨАТ-ын авлага тооцоо	34,006,024.62	-
ДҮН	34,594,201.62	144,670.74

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
7. БАРАА МАТЕРИАЛ				
Түүхий эд, материал	2,057,729,288.04	5,816,071,378.18	6,251,011,039.27	1,622,789,418.24
Дуусаагүй үйлдвэрлэл	-	8,728,072,143.48	8,728,072,143.48	-
Бараа, бэлэн бүтээгдэхүүн	63,956,721.24	9,400,618,509.33	9,376,021,323.53	88,548,484.67
Хангамжийн материал	620,963,518.69	854,106,182.00	615,032,844.95	860,036,855.74
ДҮН	2,742,646,781.37	24,798,868,212.79	24,970,140,235.51	2,571,374,758.65

Тайлбар: Компанийн бараа материал нь түүхий эд, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон хангамжийн материалаас бүрдэнэ. Түүхий эд материалд үйлдвэрлэлийн үндсэн болон туслах материал болох гурил, элсэн чихэр, тос, маргарин, өндөг зэрэг орцыг бүртгэдэг бөгөөд анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг. Материалын зарцуулалтыг дундаж өртгийн аргаар тооцож, дуусаагүй үйлдвэрлэлд шилжүүлэн бүртгэнэ.

Үйлдвэрлэлийн өртөгт шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн тогтмол болон хувьсах нэмэгдэл зардал багтдаг. Талх, гурилан бүтээгдэхүүний онцлогоос шалтгаалан дуусаагүй үйлдвэрлэл үлдэгдэлгүй байдаг бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг бэлэн бүтээгдэхүүнээр бүртгэдэг.

Тайлант оны үйлдвэрлэлийн өртгийг задлан харуулбал:

Үүнд:

- Шууд материал - 5,283,872,021
- Шууд хөдөлмөр - 814,404,950
- Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал - 2,629,795,172

Бараа, бэлэн бүтээгдэхүүн нь компанийн дотооддоо үйлдвэрлэсэн талх, гурилан бүтээгдэхүүн болон Атар-1 нэрийн дэлгүүрээр борлуулдаг бараа бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Хангамжийн бараа материалд сав баглаа боодол, шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн өртгөөр нь бүртгэдэг ба тайлант оны үлдэгдлийг задлан харуулбал:

- Сав баглаа боодол - 417,196,657
- Шатах тослох материал - 42,497,305
- Сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал - 400,342,893 төгрөг байна.

ИНТЕР АУДИТ ХХК

2025.04.29 23

ҮЗҮҮЛЭЛТ

2024.12.31

2025.12.31

8. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Урьдчилж төлсөн зардал, тооцоо	65,144,950.00	26,573,000.00
ДҮН	65,144,950.00	26,573,000.00

Тайлбар: Смарт ложик ХХК-д шилжүүлсэн програм хангамжийн 2026 оны лицензийн төлбөрийг урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэсэн. Тухайн лиценз нь тодорхой хугацаанд ашиглагдах эрх олгож байгаа тул уг зардлыг ашиглалтын хугацаанд нь системтэйгээр зардалд хүлээн зөвшөөрөхөөр бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ				
Барилга, байгууламж	13,156,063,179.06	35,000,000.00	-	13,191,063,179.06
Машин тоног төхөөрөмж	1,893,411,707.86	146,678,297.20	-	2,040,090,005.06
Тавилга, эд хогшил	207,923,289.44	7,612,090.91	-	215,535,380.35
Тээврийн хэрэгсэл	951,881,355.12	24,545,455.00	-	976,426,809.67
Компьютер, бусад хэрэгсэл	70,648,518.55	3,610,000.00	-	74,258,518.55
ДҮН	16,279,928,050	217,445,842.66	-	16,497,373,892.69

Тайлбар: Компани нь үйлдвэрлэл, борлуулалт болон удирдлагын хэрэгцээнд ашиглаж буй нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах биет хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэдэг. Барилга байгууламжийн бүлэг хөрөнгийг 2024 оны 03 дугаар сарын 31-нд дахин үнэлүүлсэн бөгөөд дахин үнэлсэн өдрийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдлийг хасаж тайлагнасан. Бусад хөрөнгийг анхны өртгөөс түүний хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр толилуулсан байна. Тайлант онд хөрөнгийн данснаас хасалттай холбоотой ажил гүйлгээ гараагүй.

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
9. ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ				
Барилга, байгууламж	532,398,029.45	283,806,056.52	-	816,204,085.97
Машин, тоног төхөөрөмж	1,374,163,890.08	118,232,210.96	-	1,492,396,101.04
Тавилга, эд хогшил	144,656,599.01	11,615,425.01	-	156,272,024.02
Тээврийн хэрэгсэл	332,357,696.04	42,075,505.16	-	374,433,201.20
Компьютер, бусад хэрэгсэл	47,216,679.08	5,115,351.27	-	52,332,030.35
ДҮН	2,430,792,897.11	460,844,548.92	-	2,891,637,442.58

Тайлбар: Компани нь тайлант онд үндсэн хөрөнгийн элэгдлийг ашиглалтад суурилсан аргаар тооцож бүртгэсэн. Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийг бэлэн бүтээгдэхүүний өртөгт шингээдэг ба удирдлага, үйлчилгээний зориулалтаар ашиглагдаж буй хөрөнгийн элэгдлийг тайлант үеийн зардалд хүлээн зөвшөөрсөн байна. Тайлант онд байгуулсан нийт элэгдлийн зардлын 13.3%-ийг тайлант үеийн зардалд бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ				
Компьютерийн программ хангамж	8,135,809.94	3,200,000.00	3,386,092.03	7,949,717.91
ДҮН	8,135,809.94	3,200,000.00	3,386,092.03	7,949,717.91

ҮЗҮҮЛЭЛТ

2024.12.31

2025.12.31

11. БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Урт хугацаат авлага	-	404,224,735.23
ДҮН	-	404,224,735.23

Тайлбар: Урт хугацаат авлага нь Бэрэн групп ХХК-с авах авлага байх ба тайлант хугацааны эцсийн байдлаар 12 сараас дээш хугацаанд төлөгдөхөөр хүлээгдэж буй дүнг урт хугацаат авлагаар ангилан толилуулсан болно.

ИНТЕР АУДИТ ХХК
Огноо 2026.04.29 (24)

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
12. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Бэлтгэн нийлүүлэгчид өгөх худалдааны өглөг	754,554,724.79	713,136,820.16
Ажиллагчдад олгох цалингийн өглөг	169,218,083.73	144,120,825.11
Ажиллагчдад өгөх өглөг	8,059,029.70	3,118,518.72
Үйлдвэрчний эвлэлийн татварын өглөг	11,180,294.43	18,162,511.96
Банкны богино хугацаат зээл	55,588,485.37	-
ДҮН	998,600,618.02	878,538,675.95

Тайлбар: Бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөг нь компанийн үйлдвэрлэл, үндсэн үйл ажиллагааны хүрээнд дотоодын харилцагчдаас авсан түүхий эд материал, бараа бүтээгдэхүүний үнэ байх ба аливаа хугацаа хэтэрсэн өр төлбөр байхгүй, богино хугацаанд барагдуулах өглөгүүд байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
13. ТАТВАР, НДШ-ИЙН ӨГЛӨГ		
Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг	551,475.45	369,362,002.13
Хувь хүний орлогын албан татварын өглөг	60,719,724.50	69,651,236.57
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг	8,707,928.76	-
Бусад татварын өглөг	5,713.13	-
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	116,785,911.98	241,697,588.43
ДҮН	186,770,753.62	680,710,827.13

Тайлбар: Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлант оны ногдол 622,666,980 төгрөг байна. Тайлагналын өдрөөс хойш аудитын тайланг бэлтгэсэн 4 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл хугацаанд дээрх НӨАТ-ын өрийг төлөөгүй байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
14. НОГДОЛ АШГИЙН ӨГЛӨГ		
Ногдол ашгийн өглөг	50,403,850.00	50,403,850.00
ДҮН	50,403,850.00	50,403,850.00

Тайлбар: Компанийн тайлант жилийн эцэс дэх ногдол ашгийн өглөг нь 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг олгохоор шийдвэрлэн том хувьцаа эзэмшигчдэд ногдох ногдол ашгийг 2020 онд өр төлбөрөөр бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31		2025.12.31	
	тоо ширхэг	дүн (төгрөгөөр)	тоо ширхэг	дүн (төгрөгөөр)
15. ХУВЬЦААТ КАПИТАЛ				
Энгийн хувьцаа	174,136.00	3,134,448,000.00	174,136.00	3,134,448,000.00
Халаасны хувьцаа	(2,509.00)	(45,162,000.00)	(2,509.00)	(45,162,000.00)
ЭРГЭЛТЭНД БАЙГАА	171,627.00	3,089,286,000.00	171,627.00	3,089,286,000.00
ЭНГИЙН ХУВЬЦАА				

Тайлбар: Компанийн хувьцаат капитал нь нэг бүр нь 18,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 174,136 ширхэг энгийн хувьцаатай ба үүнээс 2,509 ширхэг энгийн хувьцааг компани халаасалсан байна. Нэгж энгийн хувьцаа бүр нэг саналын эрхтэй, ногдол ашиг зарласан тохиолдолд түүнийг авах эрхтэй байна.

ОГНОС 2026.04.29 20

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
19. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ		
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	7,780,930,640.56	8,961,763,589.24
ДҮН	7,780,930,640.56	8,961,763,589.24

Тайлбар: Компанийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь тайлант хугацаанд борлуулсан талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой шууд материал, шууд хөдөлмөр болон үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлуудаас бүрддэг.

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
20. БУСАД ОРЛОГО		
Банкны харилцах дансанд тооцсон хүүний орлого	886,786.48	924,792.65
Бусад борлуулалтын орлого	77,342,681.93	78,663,263.55
Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	(1,161,242.65)	3,011,765.97
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(25,102,830.48)	-
ДҮН	51,965,395.28	82,599,822.17

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
21. БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ		
Ажилчдын цалингийн зардал	571,074,316.35	976,164,061.71
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ий зардал	67,349,206.58	87,203,487.38
Албан татвар ,төлбөр хураамжийн зардал	40,728,538.56	30,686,360.91
Бичиг хэргийн зардал	4,170,020.83	6,075,865.35
Шуудан холбооны зардал	21,347,976.44	23,129,693.99
Мэргэжлийн үйлчилгээний зардал	29,846,045.44	44,036,014.40
Сургалтын зардал	-	1,808,779.17
Сонин сэтгүүл захиалгын зардал	717,400.00	4,674,123.09
Даатгалын зардал	11,268,280.46	12,527,485.87
Ашиглалтын зардал	23,114,050.39	36,820,117.01
Засварын зардал	65,357,855.47	78,404,544.60
Элэгдэл, хорогдлын зардал	69,080,429.18	22,599,073.61
Түрээсийн зардал	50,752,781.57	58,389,373.99
Харуул хамгааллын зардал	26,737,575.75	-
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	2,268,522.54	2,416,348.01
Тээврийн зардал	17,516,496.29	13,162,000.00
Шатахууны зардал	117,459,853.42	113,413,297.40
Зар сурталчилгааны зардал	96,256,510.32	-
Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	43,227,594.92	40,000,673.85
Бусад зардал	357,808,616.52	78,199,455.84
ДҮН	1,616,082,071.03	1,629,710,756.18

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
22. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ		
Ажилчдын цалингийн зардал	408,446,729.87	503,965,114.16
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ий зардал	52,712,633.01	62,740,041.33
Албан татвар, төлбөр хураамжийн зардал	4,223,769.72	7,030,525.00
Бичиг хэргийн зардал	3,050,631.29	2,875,805.45
Шуудан холбооны зардал	6,517,466.88	4,183,500.48
Мэргэжлийн үйлчилгээний зардал	33,117,202.70	70,202,460.88
Ашиглалтын зардал	-	4,235,828.58
Засварын зардал	1,246,682.34	1,119,268.06
Элэгдэл, хорогдлын зардал	117,578,643.28	38,483,519.18
Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	9,671,069.40	6,640,960.33
Бусад зардал	11,767,017.07	9,447,600.53
ДҮН	648,331,845.56	710,924,623.98

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
23. БУСАД ЗАРДАЛ		
Санхүүгийн зардал	45,339,458.70	4,146,560.59
Алданги, торгуулийн зардал	54,000.00	15,913,502.40
Хандив, тусламжийн зардал	-	26,400,000.00
Найдваргүй авлагын зардал	10,125,660.20	11,401,458.01
Бусад төрөл	178,024,178.58	152,020,889.60
ДҮН	233,543,297.48	209,882,410.60

Тайлбар: Тайлант онд компани нь өөрийн хүсэлтээр 2023 оноос 2024 оныг дуустал хугацааны татварын хяналт шалгалтад хамрагдсан байна. Уг шалгалтаар нийт 259,169.62 мянган төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд 25,917 мянган төгрөгийн нөхөн татвар, 12,958.5 мянган төгрөгийн торгууль, 2,955.0 мянган төгрөгийн алданги төлүүлэхээр нөхөн ногдуулалтын акт тогтоосон байна. Үүнээс торгууль, алданги болох 15,913.5 мянган төгрөгийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31
24. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ		
Тайлант үеийн татварын зардал	-	16,863,537.43
ДҮН	-	16,863,537.43

Тайлбар: Орлогын татварын зардал нь тухайн тайлант үеийн татвар ногдуулах орлогоос ААНОАТ-ын хуулийн дагуу, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хувь хэмжээгээр тооцож гаргасан татварын зардал байна.

25. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС

Их хэмжээний ба сонирхлын зөрчилтэй хэлцэл

Тайлант онд Компанийн 40 хувийн хувьцааг эзэмшигч Бэрэн групп ХХК нь өөрийн мэдлийн хувьцааг иргэн Г.Мөнхбилэг-т борлуулсан байна. Хувьцааны саналын эрхийн маргааны тухай 2024 оны 04 дүгээр сарын 26-ны хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2023 онд Компанийн хувьцаа эзэмшигч болсон С.Адъяабазар, О.Баттулга нарын хувьцааг саналын эрхгүйд тооцсон тул тухайн иргэд Санхүүгийн Зохицуулах Хороо-нд гомдол гаргасан. Санхүүгийн Зохицуулах Хороо нь 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралтай ижил нөхцөл байдал үүссэн учир хурлыг хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар 2024 оны 09 дүгээр сард албан бичгээр мэдэгдсэн. Компанийн удирдлага Санхүүгийн Зохицуулах Хорооны мэдэгдлийг хүлээн зөвшөөрч, 2024 оны 12 сард Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан.

ИНТЕР АУДИТ ХХК

ОГНОО 2025.04.29 (28)

Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 128/ШШ2025/0210 дугаартай шийдвэрээр саналын эрхтэй эсвэл эрхгүй хувьцаа эзэмшигчийг тогтоох үйл баримт нь маргаантай байхад Компанийн тухай хууль заасан үүргээ хэрэгжүүлээгүй гэж дүгнэж, зөрчил гаргасан гэж шийтгэл ногдуулсан нь хууль бус болохыг тогтоож, шийтгэлийн хуудсыг хүчингүйд тооцсон. 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 303 тоот тушаалаар СЗХ-ны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах зөвлөхөөр ахлуулсан шалгалтын ажлын хэсэг байгуулан "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг Атар Өргөө ХК хэрэгжүүлж буй эсэхийг үнэлж дүгнэх, илэрсэн зөрчилд хариуцлага ногдуулах, тэдгээрийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх" зорилготой шалгалтыг гүйцэтгэсэн.

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр гарсан "Атар Өргөө ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын тайлан"-д дараах асуудлуудыг онцлон дурдсан байна:

- Атар Өргөө ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээд болох "Бэрэн групп" ХХК-д олгосон 1,388,225.0 мянган төгрөгийн санхүүжилтийг ТУЗ-ын шийдвэргүй олгосныг гэмт хэргийн шинжтэй гэж байж болзошгүй гэж дүгнэсэн.
- НББ-ийн бодлогын баримт бичиг нь хууль, стандартын шаардлага хангаагүй, хөрөнгө оруулагчдад ташаа мэдээлэл өгөхүйц.
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт хангалтгүй, эрсдэлтэй гэж дүгнэсэн. Мөн уг тайланд "хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж Компанийн ТУЗ-ийг шинээр томилж, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг тогтоох, "Бэрэн Групп" ХХК-иас авах авлагыг барагдуулах гэсэн арга хэмжээ авахыг тусгасан байна.

26. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 26/03 дугаар тогтоолоор 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг олгохгүй байхаар шийдвэрлэсэн байна.

